

121

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР,
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН АСУУДАЛ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2011 оны 45 сарын 45 өдөр

Дугаар 03/А/157

Улаанбаатар хот

Мэдээлэл солилцох ажлыг сайжруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 65 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 99 дугаар тушаалыг үндэслэн "Иргэний бүртгэл, паспорт хяналтын нэгдсэн сүлжээ"-ний компьютер, тоног төхөөрөмж, програм хангамжийн ашиглалтыг сайжруулахын тулд ТУШААХ НЬ:

1. Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн, албадан гаргасан болон гарахыг түдгэлзүүлснийг хүчингүй болгосон гадаадын иргэний талаарх мэдээллийг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын даргын тушаал гарсан даруйд нэгдсэн сүлжээнд шивэх, уг тушаалын хуулбарыг нэн даруй Хил хамгаалах ерөнхий газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын Хяналтын хэлтэс /Н.Баянмөнх/-т даалгасугай.

2. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газраас ирсэн тушаалын хуулбарыг өөрийн мэдээллийн санд орсон эсэхийг тулган шалгаж, ороогүй тохиолдолд нөхөн оруулах арга хэмжээг авч ажиллахыг Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн шалган нэвтрүүлэх албаны хэлтэс /Д.Мөнхчулуун/-т даалгасугай.

3. Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн, албадан гаргасан болон гарахыг түдгэлзүүлснийг хүчингүй болгосон гадаадын иргэний талаарх мэдээллийг сар бүрийн 5-ны өдрийн дотор тулгалт хийж байхыг Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн шалган нэвтрүүлэх албаны хэлтэс /Д.Мөнхчулуун/-т болон Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын Хяналтын хэлтэс /Н.Баянмөнх/-т даалгасугай.

4. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хил хамгаалах ерөнхий газрын тэргүүн дэд дарга, бөгөөд Хилийн цэргийн штабын дарга, бригадын генерал А.Лхагвасүрэн, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын дэд дарга Х.Гэрэлчулуун нарт үүрэг болгосугай.

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА-БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Д.СЭРГЭЛЭН

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.МӨРӨН

5/12

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР,
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН АСУУДАЛ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2011 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 04/А/58

Улаанбаатар хот

Хамтран ажиллах тухай

Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 39.3, Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны "Хилийн боомтын жагсаалт батлах тухай" 4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулахын тулд ТУШААХ нь:

1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 39.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 39.2-т зааснаас бусад хилийн боомтод Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын виз олгохоос бусад чиг үүргийг тухайн боомт дахь хил хамгаалах байгууллага хариуцан гүйцэтгэнэ" гэж заасны дагуу дараахь байдлаар ажилласугай. Үүнд:

1.1 Хил хамгаалах байгууллагын ажилтан нь тухайн хилийн боомтоор Монгол Улсад нэвтэрч буй гадаадын иргэнийг "Иргэний бүртгэл, паспорт хяналтын нэгдсэн сүлжээ"-гээр шалгаж нэвтрүүлэх, иргэд харилцан зорчих талаархи Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу Монгол Улсад визгүй зорчихоос бусад гадаадын иргэдийг визгүйгээр хилээр нэвтрүүлэхгүй буцаах арга хэмжээ авах;

1.2 Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газраас оршин суух зөвшөөрөл авч хасалт хийгдээгүй, виз, бүртгэл, оршин суух зөвшөөрлийн зөрчилтэй гадаадын иргэн Монгол Улсаас гарахаар тухайн боомтод ирэх тохиолдолд хил нэвтрүүлэхгүй буцаах арга хэмжээ авах;

1.3 Хил хамгаалах байгууллагын ажилтан нь Монгол Улсаас албадан гаргагдаж Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацаа дуусаагүй, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэнийг хилээр нэвтрэхийг завдсан үед илрүүлж, буцаах арга хэмжээ авах;

2. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар өөрийн төлөөлөл байхгүй боомтоор паспорт, хил орчмын нутагт зорчих үнэмлэхээр зорчсон гадаадын иргэдэд "Иргэний бүртгэл, паспорт хяналтын нэгдсэн сүлжээ"-гээр хяналт тавьж ажилласугай.

17

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хил хамгаалах ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд Хилийн цэргийн штабын дарга, бригадын генерал А.Лхагвасүрэн, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын дэд дарга Х.Гэрэлчулуун нарт үүрэг болгосугай.

ХИЛ ХАМГААВАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Ц.СЭРГЭЛЭН



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.МӨРӨН

